Golomt Capital®

ТАВААРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Алт
Нүүрс
Төмрийн хүдэр
Зэс
Газрын тос

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв *2022.06.06*

Golomt Capital®

АЛТНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 6-р сарын 6

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

- Өнгөрсөн 7 хоногт алтны ханш 0.12%-иар уналаа. Харин шинэ 7 хоногийн арилжаа 0.2 хувиар буюу 1853 ам.доллар болж өсөж нээгдлээ.

- АНУ-д инфляц өсөж, зээлийн хүүгийн дарамт нэмэгдэж байгаа ч хөдөлмөрийн зах зээлийн тоон үзүүлэлтүүд нь сайн гарсан учраас 6, 7 дугаар сард бодлогын хүүг таамаглалын дагуу хагас нэгжээр нэмэгдүүлэх магадлал өндөр байна.

- АНУ-ын богино хугацааны хүү, бондын өгөөж өндөр байгаа тул хөрөнгө оруулагчид алтыг сонирхохгүй байна.

- Өнгөрсөн сард АНУ-ын ажил олгогчид хүлээгдэж байснаас олон тооны ажилтан авч, цалин нэмэгдэж байгаа нь алтны ханшид сөргөөр нөлөөлж байна.

- Өнгөрсөн баасан гарагт Өмнөд Африкийн үнэт метал олборлогч Сибанье Стиллуотер компаниас ажил хаялт зарлаж буй үйлдвэрчний эвлэлүүд гишүүдийг гурван жилийн цалин хөлсний гэрээг хүлээн зөвшөөрөх бүрэн эрхтэй гэж мэдэгджээ.

- Гана улсын алтны үйлдвэрлэл өнгөрсөн онд 30%-иар буурч сүүлийн 10 жилийн хамгийн доод түвшинд хүрснээр тус улс Африк тив дэх шилдэг үйлдвэрлэгч гэсэн байр сууринаасаа буулаа.

- Энэхэгт хуримын улирал дуусан тул алтан эдлэлийн үнэ хямдарсан байна. Харин дэлхийн топ алт хэрэглэгч орон болох БНХАУ-д коронавирусын хязгаарлалт суларч байгаа ч алтны эрэлт сэргээгүй байна.

Мэдэгдэл: *Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.*

Golomt Capital®

ГАЗРЫН ТОСНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 6-р сарын 6

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

Саудын Араб 7 сард борлуулах газрын тосныхоо үнийг огцом нэмсний дараа даваа гарагт нефтийн үнэ хоёр ам.доллараар нэмэгдлээ. ОПЕК+ орнууд ирэх хоёр сарын хугацаанд олборлолтоо нэмэгдүүлэхээр тохиролцсон ч үнэ өсөж буй нь нийлүүлэлт хангалтгүй байгааг харуулж байна.

Брент маркийн нефтийн фьючерс 1.80 ам.доллар буюу 1.5%-иар өсөж, баррель нь 121.52 ам.долларт хүрсэн бол АНУ-ын West Texas Intermediate (WTI) нефтийн фьючерс 1.63 ам.доллар буюу 1.4%-иар өсөж нэг баррель нь 120,50 ам.долларт хүрлээ.

Өнгөрсөн 7 хоногт нефть экспортлогч орнуудын байгууллага болон холбоотнууд ОПЕК+ хамтран 7, 8 сард олборлолтоо өдөрт 648,000 баррелиар буюу өмнө нь төлөвлөж байснаас 50 хувиар нэмэгдүүлэх шийдвэр гаргасан.

Гэвч ОХУ зэрэг хэд хэдэн гишүүн орон олборлолтоо нэмэгдүүлэх боломжгүй байгаа тул эрэлтийг хангах боломжгүй байна.

Харин нөгөө талд АНУ-д автомашины жолоодлогын улирлын оргил үе тохиож БНХАУ-д COVID-ийн хөл хориог сулруулж байгаа нь эрэлтийг нэмэгдүүлж байна.

Мэдэгдэл: *Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.*